

МУИС-ийн Захиргааны зөвлөлийн 2015 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн хурлын шийдвэр:

1-р асуудалд:

1. Хөтөлбөрийн хорооны ажлын хэсгээс өгсөн 44 сурах бичгийн жагсаалтаас Зохиогчийн эрхээ МУИС-д шилжүүлэх болон Хамтран эзэмших гэсэн зохиогчидтой гэрээ байгуулж, сурах бичгийг нь хэвлэх
2. Оюутан сонгоогүй болон ерөнхий суурийн хичээлд ороогүй номыг түр хойшлуулах
3. Зохиогчтой хийх гэрээ, хамтран эзэмшигчтэй хийх гэрээ, орчуулагчтай хийх гэрээ гэсэн 3 төрлийн Гэрээ боловсруулахад ХЗС-аас хууль зүйн талаас нь зөвлөгөө авах, бизнесийн орлого олох талаас нь БС зөвлөгөө өгөх.
4. Хамтран эзэмших тохиолдолд ижил төстэй бизнесийн байгууллагын жишгийг барих

2-р асуудалд:

1. Багшийн шалгалтанд тэнцсэн, шаардлага хангасан хүмүүсийг багшаар ажиллуулах тухай шийдвэр гаргая. /тушаал гаргах/
2. Багш авах журмыг цэгцлэх, тодорхой болгох, Багшийг сонгож авч байгаа комиссын үйл ажиллагааг тусгасан заавар, зөвлөмжийг ЗХШҮА-аас гаргаж өгөх
3. Сэтгэл судлалын тэнхимийн багшийн шалгалтанд тэнцсэн 2 багшийн хувьд мэргэжлийн оноог хянаад, эцсийн шийдвэрээ дахин оруулж ирэх, Сэтгэл судлалын тэнхимд багш авах зарласан орон тооныхоо дагуу багш авах
4. Тэнхимүүд цагийн ачааллаа тооцоод дахин багш авах зар гаргах.

Бусад асуудлаар Сиси системд ороогүй хуримтлагдсан дүнгийн талаар хэлэлцээд дүрмэнд заасны дагуу 2 улирлаас дээш хугацаанд яасан нь тодорхойгүй байгаа оюутнуудыг шууд сургуулиас хасах тухай тушаал гаргах, Тодорхой шалтгаантай байсан оюутнуудын дүнг энэ семистрт багтаан яаралтай оруулах, Энэ улирлын 3900 дүнг сонголт баталгаажуулах хугацаанд багтаан оруулахаар шийдвэрлэв.